

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: ГХБХБГ-т шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах

Төслийн дугаар: ОР-213/2020

Орхон аймаг
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: **2020 оны 04-р сарын 30-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **ГХБХБГ-т шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ОР-213/2020**

Орхон аймгийн ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **ГХБХБГ-т шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах** тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг **2020 оны 05-р сарын 08-ны өдрийн 08 цаг 00 минут**-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 05-р сарын 08-ны 08 цаг 10 минутад** Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны **Сургалт мэдээллийн танхимд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын 70358570 утсаар авч болно.

Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө
Утас:70358570

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 3. Тендерийн иж бүрдэл
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- Үнийн санал маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.
 - Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ.
 - Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас скайнердаж ирүүлэх
 - Захирлын цахим иргэний үнэмлэхний эх хувиас скайнердаж ирүүлэх
 - Компанийн танилцуулга ирүүлэх
 - Шүүхийн тодорхойлолт
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт
 - Чадварын мэдээлэл /өмнөх 2 жилийн туршлагын мэдээлэл, гэрээ, гэрээг дүгнэсэн акт болон захиалагч, ашиглагч байгууллагуудын тодорхойлолтуудыг ирүүлнэ./
 - **Захиалагчийн байгууллагын тодорхойлолт:** Өмнөх гэрээг хэрхэн гүйцэтгэсэн, үр дүнгийн талаар бүх Захиалагчийн тодорхойлолтыг албан бичгээр, эх хувиар ирүүлнэ.
 - **Ашиглагч байгууллагын тодорхойлолт:** Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн чанар, одоогийн ашиглалтын талаархи мэдээллийг ашиглагч байгууллага бүрээс албан бичгээр, эх хувиар авч ирүүлнэ.
 - Одоо хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаархи мэдээллийг ирүүлнэ.
 - Гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээллийг ирүүлнэ.
 - Нийлүүлэхээр санал болгож буй барааны техник үзүүлэлт /техникийн дэлгэрэнгүй тодорхойлолт/-ыг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолттой харьцуулж хүснэгтээр баталгаажуулан ирүүлэх
 - Нийлүүлэх барааны зургийг өнгөтөөр, харагдах байдал бүрэн тодоор ирүүлэх

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-т заасан нөхцөл үүсээгүй тухай албан бичиг ирүүлэх
 - Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх
 - Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлэх
 - Баталгаат хугацаа олгох албан бичиг ирүүлэх /1 жилээс багагүй байх/
 - Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй ба барааг угсарч, суурилж өгөх тухай албан бичиг ирүүлнэ.
4. **Тогтмол үнэ** 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд** 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа** 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх** 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл** 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Тендерт санхүүгийн тайлан ирүүлэх шаардлагагүй. Санхүүгийн тайланг тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn-ээс тендерт оролцогчын санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>Борлуулалтын орлого: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх</p> <p>-Татварын тодорхойлолт: Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</p> <p>-Гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээллийг ирүүлнэ.Удирдах болон техникийн голлох албан тушаалтны цахим иргэний үнэмлэх, сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхний эх хувиас скайнердаж ирүүлэх</p> <p>-Чадварын мэдээлэл /өмнөх туршлагын мэдээлэл, гэрээ, гэрээг дүгнэсэн акт болон захиалагч, ашиглагч байгууллагуудын тодорхойлолтуудыг ирүүлнэ./</p> <p>Шаардлага: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудад нийт санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний ижил төрлийн бараа нийлүүлсэн туршлагатай байх</p> <p>-Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнтэй дүйцэх эсвэл түүнээс дээш байх</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [1] болон [2] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ <i>Байгууллагын харилцах банкин дахь дансны үлдэгдэл /Банкны тодорхойлолт болон дансны хуулгаар тодорхойлно/</i> ✓ <i>Харилцагч банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /шаардлага хангасан тохиолдолд зээл олгоно, судалж үзээд зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтуудыг үнэлгээнд харгалзахгүй./</i> ✓ <i>Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн тодорхойлолтыг хүчинтэйд тооцохгүй.</i>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн тоон гарын үсгийг ашиглан нэвтрэж цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50'000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны е-меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Сангийн сайдын 2019.12.09-ний өдрийн 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.5-т заасны дагуу Тендер хүлээн авах хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд</p>

	<p>тендерийн материал хүлээн авах боломжгүй.</p> <p>Тендер хүлээн авах хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг Төрийн худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн Тендерийн баримт бичгийн “ТОДРУУЛГА” хэсэгт байрлуулах тул тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдэд нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим сайтыг байнга шалгаж байхыг зөвлөж байна.</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл , баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт Adobe PDF шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод гаргацтай байх шаардлагатайг анхаарна уу. Уг шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч нь тендерийн материалд Хувь хүний нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиар ил болгохыг хориглосон мэдээллийг ялгаж тусад нь ирүүлнэ.Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 05-р сарын 08-ны өдөр Цаг: 08 цаг 00 минут</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: ТЕНДЕРИЙГ ЦАХИМААР ДАРААХ ГАЗАРТ НЭЭНЭ.</p> <p>Байшин, гудамжны нэр: Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Нэг цэгийн үйлчилгээ, Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны Сургалт мэдээллийн танхим</p> <p>Аймаг, хот: Орхон аймаг, Баян-Өндөр сум</p> <p>Улс: Монгол Улс</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 05-р сарын 08-ны өдөр Цаг: 08 цаг 10 минут</p>
<p>ТӨӨЗ 2.3</p>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шүүхийн тодорхойлолт 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-т заасан нөхцөл үүсээгүй тухай албан бичиг ирүүлэх 4. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх 5. Баталгаат хугацаа олгох албан бичиг ирүүлэх /1 жилээс багагүй байх/
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй.</p>

БАТЛАВ:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

- 1. Барааны тодорхойлолт:** Нийлүүлэгдэх бараа нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, үзүүлэлт, тоо ширхэг хангасан байна.
- 2. Стандарт:** Нийлүүлэгдэх бараа ОУ-ын эсвэл гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна.
- 3. Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолыг стандартын дагуу хийж эцсийн цэгт хүргэнэ. Түүнээс гарах бүх эрсдлийг нийлүүлэгч хариуцна.
- 4. Бараа хүргэх газар:** Орхон аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
- 5. Шалгалт, туршилт:** Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг шалгах зорилгоор захиалагч болон ашиглагч байгууллага нь барааг шалгаж туршилтаар ажиллуулж үзэхийг зөвшөөрсөн тухай албан бичгийг тендерт оролцогч эх хувиар тендерт баталгаажуулан ирүүлнэ.

Барааны тодорхойлолт:

№	Барааны нэр	Хэмжих нэгж	тоо ширхэг	Техникийн тодорхойлолт
1	Хурдан скайнер	ширхэг	2	Нягтрал 600 dpi Хурд 35 ppm/70 ipm: 300dpi Black &White
2	3 үйлдэлт хэвлэгч	ширхэг	4	HP LaserJet M130A брэндийн эсвэл түүнтэй дүйцэх <ul style="list-style-type: none">• Функци: Хэвлэх, хувилах, сканнер• Хэвлэх хурд: 22 хуудас хүртэл (хар)• Хэвлэх, хувилах нягтрал: 600 x 600dpi• Сканнер нягтрал: 1200 x 1200dpi• Дэлгэц: 2-Line LCD• Холболтууд: Hi-Speed USB 2.0• Тохирох хор: HP 17A (CF217A) дунджаар 1600 A4 хуудас*
3	Проекторын дэлгэц	ширхэг	1	Хэмжээ-90*120 инч /228*304 см/ Автомат удирдлагатай.
4	Тог баригч	ширхэг	1	BATTERY BACKUP TIME: 8-20 MINUTES OUTPUT: 200/208/220/230/ 240 VAC BATTERY TYPE: 12V9AH
5	Өнгөт хэвлэгч	ширхэг	1	Epson Photo L1800 Color A3 Printer брэндийн эсвэл түүнтэй дүйцэх

6	Зөөврийн компьютер	ширхэг	2	CPU i5 -1035 G4; 8GB RAM; 256 GB-SSD 14 inch display
7	Баримт үдэгч	ширхэг	1	Архивын баримт үдэх зориулалттай сайн чанарын байх
8	Гэрэлтүүлгийн иж бүрдэл	Иж бүрдэл	20	60*60 хэмжээтэй, 36 ваттын LED гэрэл 20 ширхэг, унтраалга, залгуур, кабель утасны хамт

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Хурдан скайнер	Нягтрал 600 dpi Хурд 35 ppm/70 ipm: 300dpi Black &White	2	ширхэг	Орхон аймгийн ГХБХБГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноо с хойших хугацааг бичих]
3 үйлдэлт хэвлэгч	HP LaserJet M130A брэндийн эсвэл түүнтэй дүйцэх <ul style="list-style-type: none"> • Функц: Хэвлэх, хувилах, сканнер • Хэвлэх хурд: 22 хуудас хүртэл (хар) • Хэвлэх, хувилах нягтрал: 600 x 600dpi • Сканнер нягтрал: 1200 x 1200dpi • Дэлгэц: 2-Line LCD • Холболтууд: Hi-Speed USB 2.0 • Тохирох хор: HP 17A (CF217A) дунджаар 1600 A4 хуудас* 	4	ширхэг	Орхон аймгийн ГХБХБГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноо с хойших хугацааг бичих]
Проекторын дэлгэц	Хэмжээ-90*120 инч /228*304 см/ Автомат удирдлагатай.	1	ширхэг	Орхон аймгийн ГХБХБГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноо с хойших хугацааг бичих]
Тог баригч	BATTERY BACKUP TIME: 8-20 MINUTES OUTPUT: 200/208/220/230/ 240 VAC BATTERY TYPE: 12V9AH	1	ширхэг	Орхон аймгийн ГХБХБГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноо с хойших хугацааг бичих]
Өнгөт хэвлэгч	Epson Photo L1800 Color A3 Printer брэндийн эсвэл түүнтэй дүйцэх	1	ширхэг	Орхон аймгийн ГХБХБГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноо с хойших хугацааг бичих]
Зөөврийн компьютер	CPU i5 -1035 G4; 8GB RAM; 256 GB-SSD 14 inch display	2	ширхэг	Орхон аймгийн ГХБХБГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноо с хойших хугацааг бичих]

Баримт үдэгч	Архивын баримт үдэх зориулалттай сайн чанарын байх	1	ширхэг	Орхон аймгийн ГХБХБГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноо с хойших хугацааг бичих]
Гэрэлтүүлгийн иж бүрдэл	60*60 хэмжээтэй, 36 ваттын LED гэрэл 20 ширхэг, унтраалга, залгуур, кабель утасны хамт	20	Иж бүрдэл	Орхон аймгийн ГХБХБГ	14 хоног	30 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноо с хойших хугацааг бичих]

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ ТАНАА**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. **Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
Барааг хүлээн авах комисс шалгаж, туршиж актаар хүлээн авна. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг шалгах зорилгоор захиалагч болон ашиглагч байгууллага нь барааг шалгаж туршилтаар ажиллуулж үзэхийг зөвшөөрсөн тухай албан бичгийг тендерт оролцогч эх хувиар тендерт баталгаажуулан ирүүлнэ.
2. **Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. **Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Баталгаат хугацаа 1 жилээс багагүй байна.
[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. **Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнэ төгрөгөөр төлөгдөнө.
Урьдчилгаа төлбөр: Олгохгүй.
Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр: Олгохгүй.
Барааг хүлээн авч акт үйлдсэний дараа төлөх: Захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлбөрийг 100 хувь олгоно.
Гэрээний үнийн дүнгийн [тоо]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. **Алданги оногдуулах (ГЕН - 9)²**
- а. Алданги оногдуулах хувь: Гэрээний үнийн дүнгийн 0,1 хувиар $0.0001 \times \text{дүн}$.
 - б. Алдангийн нийт дүн: Алдангийн дээд хязгаар нь гэрээний нийт дүнгийн 10 хувь байна. Дээд хязгаар хэтэрсэн тохиолдолд захиалагч тал гэрээг цуцална.

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]